Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар /Эрүүл мэндийн газар/ нь “*Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын бие бялдрыг хөгжүүлэх, ажлын үр дүнг дээшлүүлснээр хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийг улсын дундаж түвшинд хүргэх*” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах,
- Улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттайгаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж, тухайн шатны Засаг даргад танилцуулах,
- Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах,
- Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих,
- Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Эрүүл мэндийн тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 06 дугаар сарын 17, 11 дүгээр сарын 11, 12 дугаар сарын 09-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ЭМЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 138 дугаар тушаалаар ЭМЯ болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,517.3 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	42,718.5	38,408.5	-4,310.0
Бараа материал	19,120.1	23,750.4	4,630.3
Үндсэн хөрөнгө	680,729.7	666,638.5	-14,091.2

<b>Нийт хөрөнгө</b>	<b>742,568.3</b>	<b>728,797.4</b>	<b>-13,770.9</b>
Өр төлбөр	44,709.7	43,042.6	-1,667.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	697,858.6	685,754.8	-12,103.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>742,568.3</b>	<b>728,797.4</b>	<b>-13,770.9</b>

Авлага дансны үлдэгдэл 38,408.5 мянган төгрөг болж 4,310.0 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлага буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 23,750.4 мянган төгрөг болж 4,630.3 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 238,986.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- ЭМЯ-аас 308,599.2 мянган төгрөгийн, ХӨСҮТ-өөс 978,922.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Шатахууны урамшуулалд 1,10.0 мянган төгрөгийн шатахууны талон хүлээн авсан,
- Сумдын ЭМТ-д 1,287,631.6 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн,
- Үйл ажиллагаанд 234,355.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,253,668.0 мянган төгрөг болж 70,535.0 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 724.3 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авсан,
- ЭМЯ-аас 22,915.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 19,900.0 мянган төгрөгийн гүний худгийг хүлээн авсан,
- Өөрийн хөрөнгө болон УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын хандиваар 26,995.3 мянган төгрөгийн 16\*12 хэмжээтэй гал тогооны байшин барьсан гэх мэт.

Өр төлбөр дансны үлдэгдэл 43,042.6 мянган төгрөг болж 1,667.1 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өглөг 1,167.2 мянган төгрөгөөр, хувь хүмүүст төлөх өглөг 499.9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 685,754.8 мянган төгрөг болж 12,103.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,086,272.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4,500.0

мянган төгрөг, нийт зарлагыг 2,090,772.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Нормативт зардлыг **0.2** мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 55,222.5 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 7,455.1 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 0.5 мянган төгрөгөөр зэрэг **62,678.1** мянган төгрөгөөр бууруулж, нийт **2,028,094.9** мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 196,218.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 21,180.5 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 2,859.4 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 2,757.7 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 4,585.9 мянган төгрөгөөр/ төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,221,463.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,850.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,221,463.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 2,925.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,053,999.5 мянган төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 170,389.1 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	659,437.0	541,839.7	117,597.3	82.2
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,548,236.7	1,495,779.1	52,457.6	96.6
3	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	16,639.9	16,380.7	259.2	98.4
	<b>Дүн</b>	<b>2,224,313.6</b>	<b>2,053,999.5</b>	<b>170,314.1</b>	<b>92.3</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн 47,132.6 мянган төгрөг, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 2,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс хуваарилсан 58,633.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 97,967.4 мянган төгрөгийн зэрэг нийт 205,733.1 мянган төгрөгийн орлого төвлөрч, 167,324.7 мянган төгрөгийг зарцуулан, 38,408.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Анхан шатны баримттай холбоотой, бараа материалын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 90 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 15,387,603.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 153,876.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагатай гэж дүгнэсэн.

Тайлант онд Covid-19 өвчний тархалт буурч, түүнтэй холбоотой зардал буурснаар тус газрын нийт зардал өмнөх оноос 11,588,527.6 мянган төгрөгөөр буюу 75.3 хувиар буурсан тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,760,920.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 37,609.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон болно.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Байгууллагын автомашины хэрэглээг багасгаж, 3 автомашинаас 2 автомашиныг зогсоож 1 автомашиныг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглаж байна,
- Төсвийн хөрөнгөөр нормын хувцас, тавилга, эд хогшил бэлтгээгүй хэмнэлт хийж ажилласан,
- Бичиг хэргийн зардлыг хэмнэх ажлын хүрээнд байгууллагын дотоод сүлжээг сайжруулан албан бичиг, ажлын файлуудыг солилцож ажиллаж байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн тооцооны үлдэгдлийн баталгааны хуудсыг хавсралт үзүүлэлтээр нэгтгэж гаргаагүй, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг хөтөлж, авто машинуудад хийгдсэн урсгал засварын ажлуудыг бүртгээгүй, өөрийн орлогыг 2-15 хоногийн дараа тушаасан, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг бараа материалын үлдэгдлээр бүртгэж, тайлагнасан, албан хаагчдын илүү цагийн нэмэгдэл хөлсний тооцоог “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”- аар баталгаажуулж, бүртгээгүй зэрэг 90,217.5 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн боловч, тус байгууллагын санхүүгийн тайланд тайлагнагдсан 2 тээврийн хэрэгсэл өөр байгууллагын эзэмшилд бүртгэлтэй, бараа материалын худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй 21,124.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	7	111,341.9	5	90,217.5	71.4
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>111,341.9</b>	<b>5</b>	<b>90,217.5</b>	<b>71.4</b>

Өмнөх онд өгөгдсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

**4.6.1** Тус байгууллагын дарга Ж.Од, нягтлан бодогч Д.Нямаа нарт улирлын ажлын мөнгөн урамшууллыг тухай бүр олгож байсан боловч Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 25-ны А/380 дугаар тушаалаар санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсэн, ажлын дүнгээр хангалттай үнэлгээ авсан гэх үндэслэлээр 3 сарын үндсэн цалингаар тооцон урамшуулал олгохоор шийдвэрлэсний дагуу улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 5,737.7 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон

орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**4.6.2** Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг үндэслэн урсгал засварын батлагдсан төсвөөс эрүүл мэндийн системийн сургалтын төвийг барьж байгуулахад буюу хөрөнгийн зардалд тайлант онд **15,995.3** мянган төгрөгийг зарцуулсан байна. Цаашид хөрөнгийн шинж чанартай зардлыг урсгал зардалд бус холбогдох зардлын эдийн засгийн ангилалд тусган, батлуулж байх шаардлагатай.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт **253.6** мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Шинээр үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн хөрөнгийн ашиглалтын жилийг оруулаагүйгээс тайлант оны элэгдлийг дутуу байгуулсан 253.6 мянган төгрөг,

Аудитаар нийт **85,601.4** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс **24,648.9** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 60,952.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өглөө.

### **5.1 Албан шаардлага**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр дараах зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй **24,648.9** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн,

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд Ковид-19 цар тахлын шинжилгээний орлогоос нийт **60,952.5** мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн бөгөөд 01 дүгээр сарын 03-аас 10-ыг хүртэлх 371 иргэний бүртгэл цахим файлаар хийгдсэн боловч 02 дугаар сарын 27-ыг хүртэл хэдэн хүнд шинжилгээ хийсэн, хэдэн төгрөг төвлөрөх ёстой зэрэг нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.4 дэх “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж хүргүүлэв.

### 2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 64 нэр төрлийн хөрөнгийг /*Нийт хөрөнгийн 45.7 хувь*/ бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна. Мөн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэл нь Мянганы сорилын сан болон Онцгой байдлын ерөнхий газрын нэр дээр тус тус улсын бүртгэлд бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*”, УСНББОУС-ын 17.49 “... *дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай*” гэж заасантай нийцэхгүй байна

1.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

### 3. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Түлш, шатах тослох материалын **26,001.3** мянган төгрөгийн хөдлөл, өөрчлөлтийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсэн боловч санхүүгийн программд бөөн дүнгээр бүртгэсэн байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр санхүүгийн программд бичилт хийж байх.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант оны элэгдлийг дутуу байгуулсан	1	253.6					1	253.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>253.6</b>					<b>1</b>	<b>253.6</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Төлбөрийн цахим баримтаар баталгаажгаагүй худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн	1	24,648.9			1	24,648.9							
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	60,952.5					1	60,952.5					
Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоогоогүй	1							1					
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>85,601.4</b>			<b>1</b>	<b>24,648.9</b>	<b>2</b>	<b>60,952.5</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								